

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэг 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2023/100/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Өлгий хот
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Хуанган
Утас: 70422954 Цахим хаяг: huanganm@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
Аудитор: К.Еркегүл
Утас: 98420220 Цахим хаяг: Erkegulk@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Төлбөрийн акт	17
5.2 Албан шаардлага	17
5.3 Зөвлөмж.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

УЛААНХУС СУМЫН
ХӨХ ХӨТӨЛ ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Л.АЙНУР ТАНАА

2023.02.24 № 206
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Хүнсний материалын жилийн эцсийн тооллогыг нэг бүрчлэн тоолж хийгээгүйгээс үлдэгдэл бүрэн, бодитой байгаа эсэх нь тодорхойгүй, няравын хүнсний материалын тайланг хугацаанд гаргаж тооцоо бодоогүй, 2,949.9 мянган төгрөгийг анхан шатны нотлох баримтгүйгээр зарлага гаргасан, нэг хүүхдийн өдрийн хоолны нормыг хэтрүүлж 5070,7 мянган төгрөгийг үндэслэлгүй зарлага гаргасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, 26 дугаар зүйлийн 26.1, 41 дүгээр зүйлийн 41.2.3, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6, Нягтлан болох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн 5.1.3, 5.1.4, 12 дугаар зүйлийн 12.2.1, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7 дахь заалт, УСНББОУС-1 санхүүгийн тайлангийн толилуулга, УСНББОУС-12 бараа материал стандартын заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, толилуулга, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Бараа материалын тооцоо тооллого, нягтлан болох бүртгэл хөтлөлт хангалтгүй хөтлөгдсөн байна.

Аудитын гол асуудал

Хүнсний материалын бүртгэл, тооцоо, зарцуулалт, тооллого, дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>40,580,553.84</u>	<u>73,278,345.56</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	4,526,992.72
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	4,526,992.72
3121	Төгрөг	0.00	4,526,992.72
33	АВЛАГА	398,191.00	0.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	398,191.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	40,182,362.84	68,751,352.84
354	Хангамжийн материал	40,182,362.84	68,751,352.84
35410	Бичиг хэргийн материал	1,500,000.00	3,964,400.00
35420	Аж ахуйн материал	13,977,970.00	17,922,540.00
35440	Түлш, шатах тослох материал	410,002.84	8,352,002.84
35460	Хүнсний материал	13,700,330.00	27,918,350.00
35470	Бусад хангамжийн материал	10,594,060.00	10,594,060.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>708,674,241.91</u>	<u>680,907,481.36</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	708,674,241.91	680,907,481.36
392	Биет хөрөнгө	703,670,241.91	675,903,481.36
39201	Барилга, байгууламж, орон сууц	706,703,834.50	701,769,176.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	-41,012,859.80	-48,253,872.48
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	29,117,636.00	27,835,636.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-12,462,593.23	-19,252,086.15
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	34,831,332.00	27,324,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-25,574,842.66	-24,125,911.20
39214	Бусад үндсэн хөрөнгө	16,776,787.00	16,776,787.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-13,336,851.90	-14,798,048.31
39217	Ном	8,627,800.00	8,627,800.00
393	Биет бус хөрөнгө	5,004,000.00	5,004,000.00
39301	Програм хангамж	825,000.00	825,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-825,000.00	-825,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	5,004,000.00	5,004,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>749,254,795.75</u>	<u>754,185,826.92</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>755,650.00</u>	<u>4,312,176.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	755,650.00	4,312,176.00
413	Өглөг	755,650.00	4,312,176.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	1,443,308.00
4136	Бусад өглөг	755,650.00	2,868,868.00
41361	Байгууллагад төлөх өглөг	618,000.00	2,637,218.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	137,650.00	231,650.00

Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэг 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	748,499,145.75	749,873,650.92
51	Засгийн газрын хувь оролцоо	748,499,145.75	749,873,650.92
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	13,856,951.00	13,856,951.00
51101	Өмч: - төрийн	13,856,951.00	13,856,951.00
512	Хуримтлагдсан үр дүн	733,547,482.75	735,832,658.92
51210	Өмнөх үеийн үр дүн	733,547,482.75	734,458,153.75
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	1,374,505.17
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,094,712.00	184,041.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	749,254,795.75	754,185,826.92

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	303,740,364.00	386,737,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,863,264.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	4,863,264.00	-
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	4,863,264.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,863,264.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	298,877,100.00	386,737,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	287,102,600.00	343,409,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	343,409,100.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	6,506,000.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	280,596,600.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	205,000.00	900,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	205,000.00	900,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	11,569,500.00	42,428,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	11,569,500.00	42,428,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	314,938,282.69	384,960,223.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	314,938,282.69	384,960,223.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	314,938,282.69	384,910,136.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	224,076,086.00	269,341,602.28

Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэг 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210101	Үндсэн цалин	195,040,686.00	212,809,544.05
210102	Нэмэгдэл	-	47,769,812.02
210104	Урамшуулал	16,742,300.00	8,762,246.21
210105	Гэрээт ажлын хөлс	12,293,100.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,114,600.00	32,104,800.00
210201	Тэтгэврийн даатгал	21,191,800.00	21,563,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,230,700.00	2,635,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,784,600.00	2,108,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	446,100.00	526,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,461,400.00	5,270,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,831,963.00	8,822,988.00
210301	Гэрэл, цахилгаан	611,300.00	1,331,518.00
210302	Түлш, халаалт	11,220,663.00	7,491,470.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,884,310.00	5,105,190.00
210401	Бичиг хэрэг	1,447,000.00	1,032,800.00
210402	Тээвэр, шатахуун	991,515.00	3,179,990.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	344,968.00	-
210404	Ном, хэвлэл	1,100,827.00	-
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	892,400.00
2105	Нормативт зардал	24,214,905.20	38,740,980.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,018,364.00	-
210502	Хоол, хүнс	23,196,541.20	38,740,980.00
2107	Томилолт, зочны зардал	223,200.00	-
210702	Дотоод албан томилолт	223,200.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	291,900.00	730,432.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	41,900.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	730,432.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,301,318.49	30,064,144.55
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,779,455.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	920,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	20,301,318.49	27,364,189.55
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	50,087.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	50,087.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	50,087.00

Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэг 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(11,197,918.69)	1,777,076.17
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	402,571.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	402,571.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(402,571.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(11,197,918.69)	1,374,505.17

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	292371100.00	386737300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	292371100.00	386737300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	280596600.00	343409100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		343409100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	280596600.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	205000.00	900000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	205000.00	900000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	11569500.00	42428200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	11569500.00	42428200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	290771100.00	382210307.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	290771100.00	382210307.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	290771100.00	382160220.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	223070900.00	267500103.28
210101	Үндсэн цалин	194035500.00	210968045.05
210102	Нэмэгдэл		47769812.02
210104	Урамшуулал	16742300.00	8762246.21
210105	Гэрээт ажлын хөлс	12293100.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30114600.00	32104800.00
210201	Тэтгэврийн даатгал	21191800.00	21563700.00
210202	Тэтгэмжийн даатгал	2230700.00	2635300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1784600.00	2108600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	446100.00	526500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4461400.00	5270700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11359500.00	15272800.00
210301	Гэрэл, цахилгаан	1893000.00	1331518.00

Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэг 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210302	Түлш, халаалт	7466500.00	11941282.00
210303	Цэвэр, бохир ус	2000000.00	2000000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2995600.00	103500.00
210401	Бичиг хэрэг	923200.00	103500.00
210402	Тээвэр, шатахуун	555000.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	467000.00	
210404	Ном, хэвлэл	50200.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	205000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	795200.00	
2105	Нормативт зардал	22026600.00	53578000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	544600.00	
210502	Хоол, хүнс	21119300.00	53578000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	362700.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	210000.00	1046500.00
210604	Урсгал засвар	210000.00	1046500.00
2107	Томилолт, зочны зардал	223200.00	0.00
210702	Дотоод албан томилолт	223200.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	333700.00	798989.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	83700.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		798989.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	437000.00	11755528.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		7255685.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	437000.00	4499843.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	50087.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	50087.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		50087.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1600000.00	4526992.72
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1600000.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1600000.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1600000.00	0.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1600000.00	
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	4526992.72
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэг 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,856,951.00	1,094,712.00	733,547,482.75	0.00	748,499,145.75
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	13,856,951.00	1,094,712.00	733,547,482.75	0.00	748,499,145.75
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-910,671.00		-910,671.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	13,856,951.00	1,094,712.00	734,458,153.75	0.00	749,409,816.75
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		-910,671.00			-910,671.00
D08	Тайлант үеийн үр дүн			1,374,505.17		1,374,505.17
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,856,951.00	184,041.00	735,832,658.92	0.00	749,873,650.92

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	0.00	385,837,300.00	381,260,220.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	0.00	385,837,300.00	381,260,220.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	0.00	385,837,300.00	381,260,220.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	0.00	267,717,900.00	267,500,103.28
210101	Үндсэн цалин			211,994,000.00	210,968,045.05
210102	Нэмэгдэл			47,204,800.00	47,769,812.02
210104	Урамшуулал			8,519,100.00	8,762,246.21
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	0.00	32,104,800.00	32,104,800.00
210201	Тэтгэврийн даатгал			21,563,700.00	21,563,700.00
210202	Тэтгэмжийн даатгал			2,635,300.00	2,635,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал			2,108,600.00	2,108,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал			526,500.00	526,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал			5,270,700.00	5,270,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	0.00	15,272,800.00	15,272,800.00
210301	Гэрэл, цахилгаан			2,392,800.00	1,331,518.00
210302	Түлш, халаалт			10,880,000.00	11,941,282.00

Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэг 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210303	Цэвэр, бохир ус			2,000,000.00	2,000,000.00
2105	Нормативт зардал	0.00	0.00	56,750,400.00	53,578,000.00
210502	Хоол, хүнс			56,750,400.00	53,578,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	0.00	300,000.00	250,000.00
210604	Урсгал засвар			300,000.00	250,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	0.00	814,000.00	798,989.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ			814,000.00	798,989.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00	12,877,400.00	11,755,528.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал			8,377,400.00	7,255,685.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх			4,500,000.00	4,499,843.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	0.00	385,837,300.00	385,787,213.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.00	0.00	343,409,100.00	343,409,100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих			343,409,100.00	343,409,100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.00	0.00	42,428,200.00	42,378,113.00
132001	Орон нутгийн төсвөөс			42,428,200.00	42,378,113.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				4,526,992.72

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	900000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	900000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	900000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	103500.00
210401	Бичиг хэрэг		103500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	796500.00
210604	Урсгал засвар		796500.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэг нь 2022 онд хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж хичээл, сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах зорилго дэвшүүлсэн байна. Дээрх зорилгыг биелүүлэхээр дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

Цэцэрлэг нь хамран сургах тойргийнхоо цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх хувилбарт сургалт зохион байгуулж, тэдний эцэг, эх, асран хамгаалагчид мэргэжлийн тусалцаа үзүүлнэ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэг нь Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад боловсролын байгууллагуудад мөрдөж байгаа хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

Улсын Их Хурлаас Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлтөөр боловсролын салбарын байгууллагууд улсын төсвөөс санхүүжиж, БСШУС-ын харьяа Боловсролын ерөнхий газарт санхүүгийн тайлангаа нэгтгэлд тушаадаг болсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэг нь 2022 онд шалгалтад хамрагдаагүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэг нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэг 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэг нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4.9 сая төгрөгөөр буюу 0.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	4,526.9	4,526.9
Авлага	398.2	0.0	-398.2
Бараа материал	40,182.3	68,751.3	28,569.0
Үндсэн хөрөнгө	708,674.2	680,907.4	-27,766.8
Нийт хөрөнгө	749,254.7	754,185.8	4,931.1
Өр төлбөр	755.65	4,312.1	3,556.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	748,499.10	749,873.6	1,374.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	749,254.7	754,185.8	4,931.1

Мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр дансанд өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгийн данс оны эцэст 4.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь норматив зардал 3.1 сая, бараа үйлчилгээний бусад зардлын 1.1 сая төгрөгийн хэмнэлт байна.

Бараа материалын данс 28.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь хүнс, түлш шатах тослох материал, аж ахуйн материалын үлдэгдэл нэмэгдсэн нөлөөлсөн байна. Тайлант онд 79.7 сая төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч, үйл ажиллагаандаа 51.2 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө нь мөн 27.7 сая төгрөгөөр буурсан нь 13.3 сая төгрөгийг үндсэн хөрөнгө акталж, үндсэн хөрөнгөнд 27.3 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Тайлант онд 1.3 сая төгрөгийн үр дүнтэй ажилласантай холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс 1.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэг 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг сая, нийт зарлагыг сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг сая төгрөгөөр бууруулж, 385.8 сая төгрөгөөр баталсан.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт тодотгол 2 удаа хийгдсэн байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 343.4 сая төгрөгийг улсын төсвөөс, 42.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 343.4 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 42.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Орон нутгийн төсвөөс авсан санхүүжилтээс 0,05 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 381.2 сая төгрөг буюу 98.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 4.5 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Эрүүл мэндийг дэмжих	1100.0	1100.0		100%
2	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	56750.4	53578.0		94%
3	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	897.4	897.4		100%
4	Боловсролын байгууллагын багш	1100.0	0.0		0%
5	Боловсрол стандарт сургалт	224203.3	224166.4		100%
6	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	59358.0	59140.3	217.7	100%
7	Нийтлэг үйлчилгээ	42428.2	42378.1	50.1	100%
	Дүн	385837.3	381260.2	267.8	98.8%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэг нь дээд шатны төсвийн захирагчаас 0.9 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч үүнээс багш нарын үнэлгээний бичиг хэргийн материалд 0.1 сая төгрөг, урсгал засварт төрийн бус санхүүгийн байгууллагаас ирсэн 0.8 сая төгрөгийг зарцуулсан.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэг 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор К.Еркегүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/15 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 303.5 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 3.4 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага бараа, ажил үйлчилгээний зардлыг нийт дүнгээр 4.5 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд зөрчил дутагдал гараагүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд Шилэн дансны мэдээллээс шалгах программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав.

Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 75% хугацаа хоцролтын хэрэгжилтийн хувь 100% байна. Тайлант онд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 8 шийдвэр гарсныг шилэн дансанд мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар албан шаардлага өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 103.9 сая төгрөгийн 2 албан шаардлага өгөгдсөн. Хэрэгжилтийг шалгаж үзэхэд бараа материалыг тооллого тооцоотой холбоотой албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	2	103905.0	2	51952.5	50%
Зөвлөмж					
Нийт дүн	2	103905.0	2	51952.5	50%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалж төсвийн зарцуулалтыг бүрэн шалгах боломжгүй тул гүйцэтгэлийн шалгалтаар дэлгэрэнгүй шалгах шаардлагатай. Дараагийн аудитаар нярвын бараа материалын тооцоо, тооллого хийсэн байдалд нарийвчлан анхаарч үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд 1.5 сая төгрөгийн залруулга хийгдлээ. Үүнд цалингаас суутгасан 1.3 сая төгрөгийн татварын, үйлдвэрчний эвлэлийн 0.3 сая төгрөгийн өглөгийг дутуу тусгасныг залруулав.

Аудитаар нийт 37.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 8.9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 28.7 сая төгрөгийн албан шаардлага өгөгдлөө.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар дараах 8.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон. Үүнд:

1. Цэцэрлэгийн нярвын хүнсний материалын 2022 оны 2 дугаар сарын тайлангаар 9.7 сая төгрөгийн зарлага гаргасан боловч санхүүгийн программд 12.7 сая төгрөгөөр бичилт хийж, 2.9 сая төгрөгийг нотлох баримтгүйгээр илүү зарлага гаргаж тооцоонд оруулсан.

2. Нярвын хүнсний материалын тайлангаар 2022 онд 9842 хүүхэд өдөрт нийтдээ 35.8 сая төгрөгийн хүнсний материал зарцуулснаар тайлагнасан. Үүнээс 2, 3 дугаар сард 1506 хүүхэд өдөрт 9.7 сая төгрөгийн хүнс зарцуулсан бөгөөд нэг хүүхэд өдөрт 6488 төгрөг зарцуулж нэг хүүхдийн өдрийн хоолны нормыг 4013 төгрөгөөр хэтрүүлсэн. 4, 5, 9, 10, 11, 12 дугаар саруудад 8336 хүүхэд өдөрт 26.0 сая төгрөгийн хүнс зарцуулсан бөгөөд нэг хүүхэд өдөрт 3121 төгрөг зарцуулж нэг өдрийн хоолны нормыг 646 төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. 1, 2 дугаар саруудад 4, 5, 9, 10, 11, 12 дугаар саруудын нэг хүүхэд өдөрт зарцуулсан хоолны дунджаас 3367 төгрөгийг илүү зарцуулсан нь үндэслэлгүй бөгөөд нийт 1506 хүүхэд өдөрт 5.1 сая төгрөгийг үндэслэлгүй зарлага гаргаж, Засгийн газраас тогтоосон нэг хүүхдийн өдрийн хоолны нормыг их хэмжээгээр хэтрүүлсэн зөрчлүүдэд төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Аудитаар дараах 28.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

1. Цэцэрлэгийн эрхлэгчийн 2022 оны 12 дугаар сарын 16-ний өдрийн А/14 тоот тушаалаар жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийх комиссыг томилсон боловч жилийн эцсийн бараа материалын тооллогыг тооллогын комисс газар дээр нь нэг бүрчлэн тоолоогүй, бараа материалын журнал дахь үлдэгдлийг хуулж тавьснаас тооллого бодитой хийгдээгүй.

Нярвын хүнсний материалын тооцоог сар бүр хийж, үлдэгдлийг баталгаажуулж ажиллаагүйгээс оны эхэнд 13.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба тайлант онд 52.8 сая төгрөгийн хүнс худалдан авч, 38.6 сая төгрөгийн хүнс зарцуулан оны эцэст 27.9 сая төгрөг болж нэмэгдсэн боловч 5 дугаар сарын эцэст 20.0 сая төгрөгийн үлдэгдэл байснаас үзэхэд оны эхний үлдэгдэл бодитой бус байгаа зөрчилд албан шаардлага өгөв.

2. Шилэн дансанд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах тухай 0.8 сая төгрөгийн 8 шийдвэрийг мэдээлээгүй, шилэн дансанд мэдээлсэн байдал 75 хувьтай байгаа зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д "нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"

Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэг 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг”, 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийн хангаж нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж тушаалаар батлуулан, санхүү, бүртгэл, тайлагналын үйл ажиллагаандаа ашиглах;

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Санхүүгийн тайланг алдаатай илэрхийлсэн	2	1530.8			2	1530.8	2	1530.8				
Дүн	2	1530.8			2	1530.8	2	1530.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		/мянган төгрөгөөр/				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хүнсний материалын тайлангаар 9.7 сая төгрөгийн зарлага гаргасан боловч санхүүгийн программд 12.7 сая төгрөгөөр бичилт хийж, 2.9 сая төгрөгийг нотлох баримтгүйгээр илүү зарлага гаргасан.	1	2948.9	1	2948.9								
Хүнсний материалын тайлангаар 2, 3 дугаар сард 9.7 сая төгрөг зарцуулснаар тайлагнаж хүүхдийн нэг өдрийн хоолны нормативаас	1	5070.7	1	5070.7								

Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэг 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

нийтдээ 6.0 сая төгрөгөөр хэтрүүлэн хууль бус илүү зарлага гаргасан										
Бараа материалын тооллогыг бодитой хийгээгүй, хүнсний материалын их хэмжээний үлдэгдэл байгаагаар тайлагнасан	1	27918.3			1	27918.3				
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй	1	0.0					1	0.0		
Дүн	4	35937.9	2	8019.6	1	27918.3	1	0.0		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/								
	Нийт зөрчил		Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн дансанд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах тухай 8 шийдвэрийг мэдээлээгүй	1	800.0			1	800.0			
Дүн	1	800.0			1	800.0			
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Дүн	0								
Нийт дүн	1	800.0			1	800.0			